
МЭДЭЭ · 2026 оны 2-р сарын 10

2025 ОНД – ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН 30,016 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ, МЭДЭЭЛЛИЙГ ХЯНАВ



Прокурорын байгууллага 2025 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 30,016 өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг хянасан нь өмнөх оноос 7,139-ээр буюу 23.7 хувиар өсжээ. Үүнээс 88,2 хувийг нь байгууллага өөрөө шийдвэрлэсэн, 8.9 хувь нь харъяаллын дагуу шилжүүлсэн байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан гомдол, хүсэлт, мэдээлэл 2025 онд 29,306 шинээр хүлээн авсан. Тодруулбал,

- 750 буюу 2.5 хувь нь зөрчил шалган шийдвэрлэх,
- 25,385 буюу 86.6 хувь нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх,
- 213 буюу 0.7 хувь нь ял эдлүүлэх ажиллагаанд,
- 103 буюу 0.35 хувь нь шүүхэд төрийг төлөөлөх чиглэлээр гаргасан гомдол, хүсэлтүүд байна.

Мөн төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдээс нийт 1,346 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авсан нь өмнөх оноос 11.2 хувиар өсжээ. Үүнээс 61 хувь нь хүний нөөц, 2.6 хувь нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгахтай холбоотой, 36.3 хувь нь бусад асуудлаар гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/628